

Шилжилт хөдөлгөөн ба цөлжилт



Бууны сумны хөнөөх аюулаас зугтааж байгаа хүмүүс ба цөлжилт, усны хомсдол, үер, аймшигт хар шуурганы аюулаас зайлахаар нүүдэллэж байгаа хүмүүсийн хоорондын тэрхүү аюумшигт төсөөтэй байдлыг хэн ч үгүйсгэж чадашгүй (НҮБ-ын Их Сургуулийн ректор Конрад Остервальдер)

1990 оноос Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотуудын оршин суугчдын тоо нэмэгдсээр иржээ. Ялангуяа, 1999–2002 оны зудны дараа Улаанбаатар хотын уруу шилжигсэдийн тоо эрс нэмэгджээ.

Байгаль орчны улмаас бий болсон шилжилт хөдөлгөөн

Зайлшгүй, амь насанд аюул учирсан тохиолдлуудыг эс тооцвол хүмүүс нүүх шилжих шийдвэрээ “түлхэх”, “татах” хүчин зүйлсээс хамааруулан гаргадаг. Цор ганц шалтгааны улмаас ийм шийдвэр гаргана гэж бараг үгүй. Шилжих хөдөлгөөнд оролцох үндсэн шалтгаан нь: 1. Эдийн засгийн хүчин зүйл 2. Нийгмийн хүчин зүйл 3. Аюулгүй байдал алдагдсантай холбоотой хүчин зүйл 4. Байгаль орчны хүчин зүйл болно. Байгаль орчны улмаас үүссэн нүүдэл шилжилт хөдөлгөөний асуудлын нарийн тодорхойлолт гэж одоогоор байхгүй байна. Гэлээ ч өнөө үед хүлээн зөвшөөрөгдөж байгаагаар байгаль дахь физикийн, химийн, биологийн зэрэг экосистемийн өөрчлөлт нь тухайн экосистемийг хүн амьдарч болохооргүй болгож хувиргаж болох ба оршин суугчдыг шилжин нүүхээс өөр аргагүйд хүргэдэг гэх явдал юм. Гэвч өнөөдрийг хүртэл “байгаль орчны цагаач”-дад статус олгох олон улсын шийдвэр гараагүй л байна. Ганц баттай зүйл бол энэ асуудал олон сая хүний амь амьдралд нөлөөлж буй явдал юм.

Цөлжилтийн үр дагавар олон зуун сая хүний амьдралд нөлөөлнө

Байгаль орчны байдал өөрчлөгдөж байгаа шалтгаанаар 2050 он гэхэд 50-аас 700 сая хүн оршин амьдарч байгаа газар нутгаа орхиж нүүх, шилжих болно гэж янз бүрийн судалгааны үр дүн гарсан байна. Эдгээр судалгаа нь хэдийгээр нийгэм-экологийн систем ба хүний шилжилт хөдөлгөөн хоёрыг холбосон олон талт хэлхээ холбооны



төвөгтэй талыг ямар нэгэн байдлаар харуулдаг ч “байгаль орчны улмаас бий болсон нүүдэл, шилжилт хөдөлгөөн”-ий талаархи маргааныг улам өөгшүүлдэг байна. Уур амьсгал, нийгэмд гарч байгаа өөрчлөлтийн нөлөө илүү тодоор илрэхэд нүүдэл шилжилт хөдөлгөөн байгаль орчны асуудалтай холбоотой гэдгийг харуулах учир шалтгаан нь улам л тод томруун болох магадлал их байгаа бөгөөд энэ байдал хуурай гандуу газар нутагт амьдарч байгаа хүмүүст бүр ч илүү ихээр хамаарах юм. Цөлжилт нь хуурай гандуу газар нутгийн

газрын доройтол бөгөөд уур амьсгалын хэлбэлзэл, хүний үйл ажиллагаа зэргээс үүдэлтэй билээ. Дэлхийн хуурай газрын 41 хувийг ямар нэгэн байдлаар хуурай гандуу гэж үздэг. Ийм газарт амьдралын түвшин харьцангуй дорой, нярайн эндэгдэл өндөр, нэг хүнд оногдох ДНБ бага байх бөгөөд энд хоёр тэрбум орчим хүн амьдарч байна. Цөлжилт, нүүдэл шилжилт хөдөлгөөний хоорондын шалтгаан - үр дагаварын хамаарлыг саяхнаас л өөр өөр ашиг сонирхолтой бүлгүүд хүлээн зөвшөөрөх болсон бөгөөд энэ талаархи тоо баримтыг НҮБ, Засгийн газар хоорондын байгууллага, судалгааны болон бодлогын хүрээлэнгүүдээс авах боломжтой болж байна. Тухайлбал, газрын доройтлыг Мексикийн хөдөөгөөс хот руу шилжих хөдөлгөөн болоод Мексикээс АНУ руу цагаачилж байгаа шилжилт хөдөлгөөнд жинтэй нөлөө үзүүлж байгаа хүчин зүйл гэж үзэх болсон. Мексикийн хуурай гандуу газар нутгаас жилд 700,000-900,000 хүн цагаач болж гардаг ажээ (Эх сурвалж: FAO). Египет, Марокко, Нигер, Мали, Буркина-Фасо зэрэг Африкийн улс оронд явуулсан судалгаагаар газрын доройтол болон цөлжилт нь хүмүүсийн нүүдэл шилжилт хөдөлгөөнд нөлөөлдөг бөгөөд явж байгаа болон үлдэж



байгаа хүмүүсийн аль алиных нь амьжиргааны түвшин доройтдог хэмээн тогтоожээ. (Эх сурвалж: UNU-EHS).



НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх Конвенц ба 10 жилийн стратеги

НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх Конвенцийн шинэ 10 жилийн стратегийн нэг тулгуур нь цөлжилт, шилжилт хөдөлгөөний асуудал юм. Цөлжилттэй тэмцэх тэмцэлд амжилт олсон арга замыг тодорхойлох, тэдгээрийг дэмжих бололцоог хангаж өгөх шинэ орчныг бүр эхнээс нь дэмжиж хөгжүүлэхээр болсон байна. Үүний зэрэгцээ байгаль орчны буюу экологийн цагаачдын статусыг дээшлүүлж байгаль орчноос бусад шалтгааны улмаас дүрвэгсдийн ижлээр хамгаалуулах эрх эдлүүлэх ёстой гэжээ. НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх Конвенц нь цөлжилт, газрын доройтол, ган гачиг болон хүн амын шилжилт хөдөлгөөний асуудалтай тэмцэхийн тулд өөрийн боломжтой арга, хэлбэр бүхнээ янз бүрийн арга замаар ашиглаж байна:

- **Цөлжилт, газрын доройтол, ган гачиг ба шилжилт хөдөлгөөний харилцан үйлчлэлийн талаархи мэдлэг.** Шилжилт хөдөлгөөний талаарх бодлогыг тодорхойлох, түүнийг сурталчлах явдал нь ерөнхийдөө хөгжиж буй орнууд дундаас хамгийн ядуу гэгдэх өөрөөр хэлбэл газрын доройтолд хүчтэй нэрвэгдсэн хүн ам хоорондын нийгэм, байгаль орчин, улс төр, соёлын харилцан үйлчлэл зайлшгүй байх ёстойг шаарддаг. Амьдрах орчиндоо дасан зохицох ба мөн эдийн засгийн боломж бага, байгаль орчны нөхцөл байдал нь сул тал ихтэй шалтгаанаар залуу үе нүүж, шилжиж байгаа үйл явцын сөрөг хандлагыг багасгахад эдгээр бүс нутагт олон нийтийн болон зохион байгуулалтын янз бүрийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх энэ чиглэлээр хөгжил дэвшилд хүрэх явдал нь тэргүүн зэргийн зорилтын нэг байх ёстой.
- **Хөгжингүй улс орнууд хамтын ажиллагааг өрнүүлэх, хөрөнгө оруулалт хийх явдлыг дэмжих.** Байгаль орчны учир шалтгааны улмаас бий болсон шилжилт хөдөлгөөнд хамрагдаж байгаа хүмүүсийг хүлээн авч байгаа хөгжингүй улс орнууд тухайн нэрвэгдсэн улс орны хуурай гандуу газар нутагт хамтын ажиллагааг өрнүүлж, хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлэх, мөн эмзэг экосистемийн байгаль орчны тогтвортой байдлыг дээшлүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагааныхаа цар хүрээг нэмэгдүүлж болно. Ингэсэн тохиолдолд

шилжилт хөдөлгөөнд өртсөн тухайн хүн амын амьдрал амьжиргааны нөхцөл байдал ч мөн дээшлэх юм.

- **Эрсдэлийн зохистой менежмент.** НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх Конвенцоос бүс нутаг, дэлхийн түвшинд ган гачигийн үзүүлэх нөлөөлөлд анхаарлаа хандуулах зорилгоор НҮБ-ын эрсдэлийн асуудлыг хариуцах холбогдох агенлагуудтай хамтран ажиллахыг зорьж байна. Өнөөгийн уур амьсгалын өөрчлөлт, ус салхины элэгдэл, хөрсний шим тэжээлийн алдагдал, усны хомсдол зэрэг асуудлууд нь дэлхийн өнцөг булан бүрд нөлөөлж байдаг. Хөгжиж буй орнуудад байгаа доройтолд орсон хуурай гандуу газар нутагт эдгээр зүйлс тохиолдоход хүн амд нь дүрвэх шилжилт хөдөлгөөн хийх шахалт дарамт нэмэгдэж, эдгээрээс тэргүүлэх хэсэг нь хот суурин газар, газар тариалангийн бүс нутаг, эсвэл гадаад улс орон тэр дундаа ихэвчлэн умардын улс орон луу шилжин нүүдэг.
- **Уламжлалт тогтвортой технологийг хүлээн зөвшөөрөх түүнийг амьдралдаа хэрэглэх асуудал.** Цөлжилт ба ган гачигтай тэмцэх асуудалд уламжлалт тогтвортой арга ажиллагаа, технологийг хэрэглэх явдлыг Үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр (National Action Programme, NAP)-өөр дамжуулан дэмжиж болно.
- **Цөлжилт ба хүний эрхийн асуудлын хоорондын холбоо.** НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх Конвенц ба НҮБ-ын тусгай төлөөлөгчийн хамтран хэвлүүлсэн Хүний хооллох эрхийн талаархи тайланд цөлжилт, газрын доройтол, ган гачигтай тэмцэх ажиллагаанд ямар нэгэн байдлаар эрх өгөх аргыг хэрэглэх нь хэт олборлолт, уур амьсгалын өөрчлөлтийн хавсарсан аюулд нэрвэгдсэн орчинд амьдарч байгаа бага орлоготой хүн ардын эрхийг хамгаалах үйл явцад зайлшгүй шаардлагатай чухал хандив гэж тодорхойлжээ.

Мянганы хөгжлийн зорилт болон холбогдох бусад олон улсын санал санаачлагатай уялдуулан НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх Конвенц цөлжилт, газрын доройтол, ган гачигтай боломжтой бүхий л аргаар зарим тохиолдолд хатуу рагаар тэмцэж хуурай гандуу газар нутаг дахь ядуурлыг бууруулах зорилттой ажиллаж байна. Үүнийг зөвхөн судалгаагаар биш, мөн амжилтад хүрсэн бусад арга ажиллагааг боловсронгуй болгон хөгжүүлэх, мөн хуулбарлаж хэрэгжүүлэх болно. Энэхүү ажлыг үргэлжлүүлэх зорилгоор НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх Конвенц ба НҮБ-ийн Их сургуулийн Байгаль орчин, хүний аюулгүй байдлын сургууль хамтран баримтад тулгуурлах ба бодлогын яриа хэлэлцээг хөхүүлэн дэмжих зорилгоор хүн амын шилжилт хөдөлгөөн ба цөлжилт хоорондын холбооны тал дээрх хамтын судалгаагаа нэмэгдүүлэх, урагш ахиулах чиглэлээр ажиллахаар боллоо.

НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх Конвенц, НҮБ-ын бусад агентга, иргэний нийгмийн байгууллага хоорондын хамтарсан, харилцан уялдаа холбоо бүхий үйл ажиллагааны үр дүнд цөлжилт, газрын доройтлын эсрэг нийтийн тэмцэл ялж, “Чөлөөтэй шилжин аялах эрх гэдэг бол үлдэх эсэхээ сонгох эрх юм” гэсэн хэлц үг бодитойгоор биелэх боломжтойг харуулах болно.

This fact sheet was prepared
in cooperation with:



UNITED NATIONS
UNIVERSITY
UNU-EHS
Institute for Environment
and Human Security